



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.14 № 55

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд 2023 онд өөрчлөлт орсон. Тайлант онд цэцэрлэгийн 70 жилийн ойн баяр тэмдэглэсэн. Улсын төсвөөс 830.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 60.1 сая төгрөг нийт 890.7 сая төгрөгийн санхүүжилт авч 8-н хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан. Жилийн эцсээр зарцуулагдаагүй төсвийн үлдэгдэл 2.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж 141.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Урьд онд авсан 2500.0 мянган төгрөгийн үнэтэй компьютерын үнийг шилжүүлсэн 2.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч бүртгэлд тусган 3.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө актлуулсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад нэг бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 4-р түвшинд үнэлэгдэн 7739.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үр дүнгийн урамшуулалд 5030.9 төгрөгийн зарцуулсан.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

АРВАЙХЭЭР СУМЫН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ч.ДОНИДДЭМБЭРЭЛ ТАНАА

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРЭҮҮЭХ
АУДИТЭР



О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76892307.49	208656836.78
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16984729.49	141393676.78
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	16984729.49	141393676.78
3121	Төгрөг	16984729.49	141393676.78
31211	Төрийн сангийн харилцах	16984729.49	141393676.78
33	АВЛАГА	9240.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	9240.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	59898338.00	67263160.00
354	Хангамжийн материал	59898338.00	67263160.00
35420	Аж ахуйн материал	360000.00	1697600.00
35450	Барилгын засварын материал	3405750.00	200000.00
35460	Хүнсний материал	4232200.00	2321950.00
35470	Бусад хангамжийн материал	51793388.00	63043610.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	525264100.84	494634152.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	525264100.84	494634152.26
392	Биет хөрөнгө	449599100.84	419149152.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	469628396.02	469628396.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-66617662.78	-84568953.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50363169.17	51810285.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20003426.65	-27120225.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32308522.52	32268522.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23899537.20	-28504726.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	6505357.32	6505357.32
39215	Хуримтлагдсан элэгдэл	-890917.56	-1039403.82
39217	Ном	2205200.00	169900.00
393	Биет бус хөрөнгө	75665000.00	75485000.00
39301	Програм хангамж	1390000.00	900000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-625000.00	-315000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	74900000.00	74900000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	602156408.33	703290989.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2766578.00	4541167.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2766578.00	4541167.00
413	Өглөг	2766578.00	4541167.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	138392.00	4541167.00
4136	Бусад өглөг	2500000.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2500000.00	0.00

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	599389830.33	698749822.04
51	Засгийн газрын хувь оролцоо	599389830.33	698749822.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	359748973.00	359748973.00
51101	Өмч: - төрийн	359748973.00	359748973.00
512	Хуримтлагдсан үр дүн	116658209.65	216018201.36
51210	Өмнөх үеийн үр дүн	108569558.95	116658209.65
51220	Тайлант үеийн үр дүн	8088650.70	99359991.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	122982647.68	122982647.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	602156408.33	703290989.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	635194860.00	902724070.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14269500.00	12055870.00
120	Нийтлэг татварын бус орлого	14269500.00	12055870.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14269500.00	12055870.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	8095000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14269500.00	3960870.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	620925360.00	890668200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	544246900.00	830534800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	544246900.00	830534800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76678460.00	60133400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76678460.00	60133400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	627031709.30	801328778.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	627031709.30	801328778.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	627031709.30	793981811.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417920161.66	519635741.12
210101	Үндсэн цалин	313826610.59	364166832.12
210102	Нэмэгдэл	86367592.48	132172390.80
210104	Урамшуулал	17725958.59	23296518.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51407254.85	65701347.59
210201	Тэтгэврийн даатгал	35320314.20	45221948.63
210202	Тэтгэмжийн даатгал	4044071.07	5329935.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	3429257.66	4187039.54
210204	Ажилгүйдлийн даатгал	780630.44	996384.05
210205	Эрүүл мэндийн даатгал	7832981.48	9966040.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41564086.00	47689146.76

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	544246900.00	830534800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	544246900.00	830534800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76678460.00	60133400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76678460.00	60133400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	603040630.51	772174252.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	603040630.51	772174252.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	603040630.51	764827285.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417781769.66	515232966.12
210101	Үндсэн цалин	313688218.59	359764057.12
210102	Нэмэгдэл	86367592.48	132172390.80
210104	Урамшуулал	17725958.59	23296518.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51416494.85	65692107.59
210201	Тэтгэврийн даатгал	35329554.20	45212708.63
210202	Тэтгэмжийн даатгал	4044071.07	5329935.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	3429257.66	4187039.54
210204	Ажилгүйдлийн даатгал	780630.44	996384.05
210205	Эрүүл мэндийн даатгал	7832981.48	9966040.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41435900.00	47817332.76
210301	Гэрэл, цахилгаан	4573032.00	7090976.76
210302	Түлш, халаалт	31668518.00	34968400.00
210303	Цэвэр, бохир ус	5194350.00	5757956.00
2105	Нормативт зардал	66006280.00	95756600.00
210502	Хоол, хүнс	66006280.00	95756600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7300000.00	10000000.00
210604	Урсгал засвар	7300000.00	10000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1258000.00	1073700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1258000.00	1073700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17842186.00	29254579.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13492186.00	24610679.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4350000.00	4643900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	7346967.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	5030900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	5030900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	2316067.24
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2316067.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17884729.49	126588947.29
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	900000.00	2180000.00

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	900000.00	2180000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	900000.00	2180000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	900000.00	2180000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-900000.00	-2180000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	16984729.49	124408947.29
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	16984729.49
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16984729.49	141393676.78

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	359,748,973.00	122,982,647.68	108,569,558.95	0.00	591,301,179.63
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	359,748,973.00	122,982,647.68	108,569,558.95	0.00	591,301,179.63
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	8,088,650.70	0.00	8,088,650.70
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	359,748,973.00	122,982,647.68	116,658,209.65	0.00	599,389,830.33
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	359,748,973.00	122,982,647.68	116,658,209.65	0.00	599,389,830.33
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	359,748,973.00	122,982,647.68	116,658,209.65	0.00	599,389,830.33
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	99,359,991.71	0.00	99,359,991.71
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	359,748,973.00	122,982,647.68	216,018,201.36	0.00	698,749,822.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	624388600	603940631	918791500	774354253
21	УРСГАЛ ЗАРДАЛ	624388600	603940631	918791500	774354253
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	624388600	603940631	913760600	767007285
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425536700	417781770	605372800	515232966
210101	Үндсэн цалин	358582500	313688219	428604300	359764057
210102	Нэмэгдэл	62480000	86367592	164324500	132172391

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21010 4	Урамшуулал	4474200	17725959	12444000	23296518
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53191800	51416495	75812300	65692108
21020 1	Тэтгэврийн даатгал	36170600	35329554	51597800	45212709
21020 2	Тэтгэмжийн даатгал	4255400	4044071	6053900	5329935
21020 3	ҮОМШӨ-ний даатгал	3404100	3429258	4649000	4187040
21020 4	Ажилгүйдлийн даатгал	851000	780630	1404400	996384
21020 5	Эрүүл мэндийн даатгал	8510700	7832981	12107200	9966040
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37540500	41435900	50133400	47817333
21030 1	Гэрэл, цахилгаан	5062500	4573032	9135000	7090977
21030 2	Түлш, халаалт	28716000	31668518	34968400	34968400
21030 3	Цэвэр, бохир ус	3762000	5194350	6030000	5757956
2105	Нормативт зардал	80816400	66006280	123585400	95756600
21050 2	Хоол, хүнс	80816400	66006280	123585400	95756600
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7300000	7300000	10000000	10000000
21060 4	Урсгал засвар	7300000	7300000	10000000	10000000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1258000	1258000	1377700	1073700
21080 6	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1258000	1258000	1377700	1073700
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18745200	18742186	47479000	31434579
21090 1	Бараа үйлчилгээний бусад зардал	13495200	13492186	42835100	26790679
21090 2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5250000	5250000	4643900	4643900
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	0	5030900	7346967
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0	0	0	2316067
21310 1	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0	0	0	2316067
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	0	5030900	5030900
21320 9	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	0	5030900	5030900

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	624388600	620925360	891749700	890668200
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	624388600	620925360	891749700	890668200
12200	Орон нутгийн төсвөөс	624388600	620925360	891749700	890668200
5					
4	<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u>	0	0	0	16984729
5	<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u>	0	16984729	0	141393677
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0	0	32	32
62000	Удирдах ажилтан	-	-	1	1
1					
62000	Гүйцэтгэх ажилтан	-	-	21	21
2					
62000	Үйлчлэх ажилтан	-	-	10	10
3					
62000	Гэрээт ажилтан	-	-	-	1
4					
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	0	0	307	200
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	0	0	0	1
63000	Төрийн өмчит ЕБС	-	-	-	1
1					

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Зорилго-Өөртөө итгэлтэй эрүүл чийрэг хүнлэг энэрэнгүй иргэн болгон төлөвшүүлэх. Зорилт Бага насны хүүхдийг асран хамгаалах тэднийг тоглоомоор дамжуулан бие бялдар оюун ухаан нийгэмшихүйн эерэг хүмүүжил олгох . Чиг үүрэг-Хүүхэд бүр аюулгүй ,тохилог орчинд бүтээлч үйлээр тоглонгоо хөгжиж төлөвшинө.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

2023 онд Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд өөрчлөлт орсон. байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг бусад хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний	Эцсийн	Өөрчлөлт

	үлдэгдэл	үлдэгдэл	
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16984.7	141393.7	124409.0
Авлага	9.2	0.00	-9.2
Бараа материал	59898.3	67263.2	7364.9
Үндсэн хөрөнгө	525264.1	494634.2	-30629.9
Нийт хөрөнгө	602156.4	703291.0	101134.6
Өр төлбөр	2766.6	4541.2	1774.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	599389.8	698749.8	99360
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	602156.4	703291.0	101134.6

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс өссөн шалтгаан нь:

Тайлант онд Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл урьд онтой харьцуулахад 124409.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө буурсан шалтган нь худалдан авсан тавилга, тоног төхөөрөмж 2180.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Тайлант оны элэгдлийн зардал 30774.6 мянган төгрөг, акталсан хөрөнгө 3298.2 мянган төгрөг болсон нь гол нөлөөг үзүүлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь төсвийн төслөө цахимаар хийдэг болсон. 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 629.4 сая төгрөгөөр тоохон төлөвлөж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас урсгал үйл ажиллагааны зардлыг 261.2 илүү / МУЗГазрын 2023 оны 6-р сарын 21-ны 241-р тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой / тогтмол зардлыг 60.1 сая төгрөгийн төсвийн саналаар тоохон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 890.6 сая төгрөгийг төсвийг баталсан. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 830.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээр 60.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 769.7 сая төгрөг буюу 86.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин хөлсний зардлын төсвийг 90.1 сая төгрөгөөр хүүхдийн хоолны зардлын төсвийг 27.8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 7.0 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801/81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх	517769.3	434327.9	83441.4	84
2	71801/81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах	148749.0	134667.3	14081.7	91
3	71801/81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	101988.0	90159.9	11828.1	88

4	71801/81605Эрүүл мэндийг дэмжих	2322.0	1550.0	772	67
5	71801/81816 Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	7983.9	7983.9	0.00	100
6	71801/81823 Боловсролын байгууллагын багш,ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	2322.0	2322.0	0.00	100
7	71801/80111Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	60133.4	57817.3	2316.1	96
8	71801/81832 Нүүдлийн бүлэг	49400.6	42174.8	7225.8	85
9	71801/83602.83603	8060.0	1000.0	7060.0	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тус байгууллагын хувьд нэмэлт төсөв, санхүүжилт аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хүрээнд 2023 онд тус цэцэрлэг 11 байгууллагатай бүтээгдэхүүн ажил үйлчилгээ худалдан авах гэрээ хийсэн.Үүнд:

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал- 95756.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн үйлчилгээ-1550.0 мянган төгрөг, Мэдээлэл технологийн- 1073.7 мянган төгрөг, Тоног төхөөрөмж -2180.0 мянган төгрөгөөр худалдан авсан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг "Дөлгөөнхайрхан Уул Аудит" ХХК-ын аудитор Д.Дашзэвэг, аудиторын туслах Д.Даваасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Дөлгөөнхайрхан Уул Аудит" ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 03 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зарлагын 627.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой 29 хуулийн шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн.

Энэ хуулийн хүрээнд цалин хөлсний зардал, хүүхдийн хоолны зардал, бараа үйлчилгээний бусад зардал хэмнэсэн. Төсвийн харилцах дансанд 141.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан. Хүүхдийн хоолны зардал хэмнэсэн шалтгаан нь хүүхдийн ирцтэй холбоотой байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзэхэд нийт 159 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан мэдээлэл 149, хугацаа хоцорсон мэдээлэл 5, хугацаа нь болоогүй 5 мэдээлэл байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг FAS программд оруулсан мэдээллийн дагуу тухайн байгууллагын шилэн дансны сайтаас мэдээллийг шалгасан.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай гэж үнэлсэн

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тухайн байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд тус байгууллагын хувьд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	1	2500.0	1	2500.0	100
Зөвлөмж	2	0	2	0	
Нийт дүн	3	2500.0	1	2500.0	

/мянган төгрөгөөр/

Өмнөх аудитаар" Төсвийн тухай хуулийн 6.4.3 төсвийг зохистой удирдаж авлага өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалттай холбоотой албан шаардлага, Бараа материалын тайлан, эд хөрөнгийн тооллоготой холбоотой зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал өглөг авлагын тооцоо, амралтын цалингийн тооцоолол.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цалингаас суутгасан ХХОАТ-ын өглөгийг тайланд тусгаагүй 4541.2 мянган төгрөгийг аудитын явцад залруулсан.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн эд хөрөнгийн тооллогыг тооцоо бодож баталгаажуулаагүйд 1 албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт 2000.0 сая төгрөгийн зөрчил.

5.2 Албан шаардлага

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн зөрчил барагдаагүйд 1 албан шаардлага өгсөн.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй .

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингаас суутгасан хаасатварын өглөгийг тайланд тусгаагүй	1	4541.2	1	4541.2	0	0	1	4541.2	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх аудитороос өгсөн зөвлөмжийн Эд хөрөнгийн тооллогын эд хариуцагчийн тооцоо бодож баталгаажуулаагүй	1	63043.6			1	63043.6						
Төсвийн тухай хуулийн 6.4.1-р заалт, 7.7-р заалт зөрчсөн			1	2000.0								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл хоцроосон	0	0	0	0	0			
Дүн	00	00	00	00	00	00	00	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	00	00	00	00	00	00	0
Нийт дүн	00	00	00	00	0	00	00	0

Нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил гараагүй.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

